



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/370

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Номын сангийн 24 айлын дундах тохижилт болон Төрийн банкны зээлийн төвийн зогсоолын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б. Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Б. Туулайтулга - Жаргалант сумын засаг даргын орлогч

Б.Ганзориг - Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч

Г. Энхжин - "Наран тулгуур" ХХК-ний захирал

Нарийн бичгийн дарга:

Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

2. “Наран тулгуур” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Номын сангийн 24 айлын дундах тохижилт болон Төрийн банкны зээлийн төвийн зогсоолын ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН